

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/262/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал.....
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт.....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/190
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 12 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж 94,6 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход

019028166

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	123,324,135.28	120,517,718.15
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	70,042,757.21	68,136,191.87
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	70,042,757.21	68,136,191.87
9	Төгрөг	70,042,757.21	68,136,191.87
10	Төрийн сангийн харилцах	70,042,757.21	68,136,191.87
60	БАРАА МАТЕРИАЛ	53,281,378.07	52,381,526.28
61	Түүхий эд материал		1,737,860.00
62	Тусгай зориулалттай материал		1,737,860.00
66	Хангамжийн материал	53,281,378.07	50,643,666.28
67	Бичиг хэргийн материал	3,800,100.00	1,868,400.00
68	Аж ахуйн материал	14,710,240.85	11,320,941.00
72	Хүнсний материал		354,150.00
73	Бусад хангамжийн материал	34,771,037.22	37,100,175.28
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	742,711,032.22	781,344,386.23
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	742,711,032.22	781,344,386.23
108	Биет хөрөнгө	713,533,972.22	752,393,166.23
109	Барилга, байгууламж	665,560,192.95	665,560,192.95
110	Хуримтлагдсан элэгдэл	(61,408,167.39)	(75,121,409.91)
113	Машин, тоног төхөөрөмж	115,416,467.01	187,921,032.01
114	Хуримтлагдсан элэгдэл	(56,338,269.36)	(71,243,330.58)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,684,224.66	75,604,224.66
116	Хуримтлагдсан элэгдэл	(24,927,617.60)	(32,956,343.93)
122	Бусад үндсэн хөрөнгө	6,571,270.40	6,571,270.40
123	Хуримтлагдсан элэгдэл	(3,443,778.45)	(4,362,119.37)
125	Номын фонд	419,650.00	419,650.00
126	Биет бус хөрөнгө	29,177,060.00	28,951,220.00
127	Програм хангамж	903,360.00	903,360.00
128	Хасагдуулга	(282,300.00)	(508,140.00)
129	Бусад биет бус хөрөнгө	28,556,000.00	28,556,000.00
224	Өмнөх үеийн үр дүн	80,216,135.49	80,216,135.49
225	Тайлант үеийн үр дүн		35,826,936.88
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	573,006,763.86	573,006,763.86
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	866,035,167.50	901,862,104.38

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,742,807,896.87	1,055,124,117.30
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	808,775,496.87	82,366,817.30
77	Нийтлэг татварын бус орлого	808,775,496.87	82,366,817.30
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	808,775,496.87	82,032,741.30
82	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,710,600.00
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		150,648.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	808,775,496.87	80,171,493.30
92	Бусад орлого		334,076.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	934,032,400.00	972,757,300.00
112	Улсын төвлөрсөн төсвөөс	735,322,400.00	838,538,600.00
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	730,308,700.00	838,538,600.00
115	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,013,700.00	
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,386,600.00	
126	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	62,386,600.00	
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	136,323,400.00	134,218,700.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	136,323,400.00	134,218,700.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	876,772,729.37	1,002,293,420.42
148	УРСГАЛ ЗАРДАЛ	876,772,729.37	1,002,293,420.42
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	769,802,261.30	969,095,515.00
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	525,931,767.78	641,628,845.24
151	Цалин	369,818,334.54	431,025,958.17
152	Нэмэгдэл цалин	126,553,652.46	183,467,209.68
153	Унаа хоолны хөнгөлөлт	1,436,000.00	
154	Урамшуулал	28,123,780.78	27,135,677.39
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,105,987.18	79,184,733.10
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	45,755,085.85	54,672,578.34
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,319,106.02	6,784,840.76
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,245,204.59	4,619,021.54
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	980,599.17	1,098,325.66
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	9,805,991.55	12,009,966.80
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,331,229.76	131,961,534.58
165	Гэрэл цахилгааны зардал	6,051,114.76	8,561,234.58
166	Түлш, халаалтын зардал	94,587,015.00	122,612,800.00
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		17,003,760.00
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)		(17,003,760.00)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	934,032,400.00	973,242,024.00
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		484,724.00
78	Нийтлэг татварын бус орлого		484,724.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого		150,648.00
84	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		150,648.00
92	Бусад орлого		334,076.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	934,032,400.00	972,757,300.00
111	Улсын төвлөрсөн төсвөөс	735,322,400.00	838,538,600.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	730,308,700.00	838,538,600.00
114	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,013,700.00	
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,386,600.00	
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	62,386,600.00	
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	136,323,400.00	134,218,700.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	136,323,400.00	134,218,700.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	848,783,642.79	975,148,589.34
148	УРСГАЛ ЗАРДАЛ	848,783,642.79	975,148,589.34
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	742,067,384.72	940,212,823.92
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	525,931,767.77	641,527,135.14
151	Үндсэн цалин	365,711,807.72	436,368,072.62
152	Нэмэгдэл	130,660,179.27	178,023,385.13
153	Унаа хоолны хөнгөлөлт	1,436,000.00	
154	Үр дүнгийн урамшуулал	28,123,780.78	27,135,677.39
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	66,105,987.19	79,286,443.20
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	45,755,085.86	55,172,490.90
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,319,106.02	5,852,389.16
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,245,204.59	5,058,394.29
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	980,599.17	1,193,202.05
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	9,805,991.55	12,009,966.80
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	102,331,229.76	132,295,610.58
165	Гэрэл цахилгааны зардал	6,051,114.76	8,561,234.58
166	Түлш, халаалтын зардал	95,587,015.00	122,946,876.00
167	Цэвэр, бохир усны зардал	693,100.00	787,500.00
181	Нормативт зардал	12,133,300.00	18,194,300.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
2	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	177,684,997.75	308,462,126.00	(92,737,566.59)	393,409,557.15
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	177,684,997.75	308,462,126.00	(92,737,566.59)	393,409,557.15
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		0	(17,404,416.06)	(17,404,416.06)
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	212,812,268.15	573,006,763.86	80,216,135.49	866,035,167.50
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	212,812,268.15	573,006,763.86	80,216,135.49	866,035,167.50
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,812,268.15	573,006,763.86	80,216,135.49	866,035,167.50
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	35,826,936.88	35,826,936.88
18	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	212,812,268.15	573,006,763.86	116,043,072.37	301,862,104.38

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		70,042,757.21	(70,042,757.21)	
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,018,423,965.42	974,891,423.92	43,532,541.50	95.7
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,018,423,965.42	974,891,423.92	43,532,541.50	95.7
4	Бараа, үйлчилгээний зардал	980,634,965.42	940,212,823.92	40,422,141.50	95.9
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамш	690,646,700.00	641,527,135.14	49,119,564.86	92.9
6	Үндсэн цалин	466,868,100.00	436,368,072.62	30,500,027.38	93.5
7	Нэмэгдэл	191,882,800.00	178,023,385.13	13,859,414.87	92.8
9	Урамшуулал	31,895,800.00	27,135,677.39	4,760,122.61	85.1
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,331,500.00	79,286,443.20	7,045,056.80	91.8
12	Тэтгэврийн даатгал	58,705,100.00	55,172,490.90	3,532,609.10	94.0
13	Тэтгэмжийн даатгал	6,906,700.00	5,852,389.16	1,054,310.84	84.7
14	ҮОМШӨ ний даатгал	5,525,200.00	5,058,394.29	466,805.71	91.6
15	Ажилгүйдлийн даатгал	1,381,700.00	1,193,202.05	188,497.95	86.4
16	Эрүүл мэндийн даатгал	13,812,800.00	12,009,966.80	1,802,833.20	86.9
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,475,865.42	132,295,610.58	180,254.84	99.9
18	Гэрэл цахилгаан	8,918,500.00	8,561,234.58	357,265.42	96.0
19	Түлш, халаалт	122,769,865.42	122,946,876.00	(177,010.58)	100.1
20	Цэвэр, бохир ус	787,500.00	787,500.00		100.0

30	Нормативт зардал	20,773,800.00	18,194,300.00	2,579,500.00	87.6
32	Хоол, хүнс	20,773,800.00	18,194,300.00	2,579,500.00	87.6
34	Эд хогшил худалдан авах	2,000,000.00	2,000,000.00		100.0
38	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00		100.0
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,869,900.00	5,336,300.00	533,600.00	90.9
49	Мэдээллийн технологийн зардал	5,869,900.00	5,336,300.00	533,600.00	90.9
53	Бараа үйлчилгээний бусад зардал	42,537,200.00	61,573,035.00	(19,035,835.00)	144.8
54	Бараа үйлчилгээний бусад зардал	34,532,800.00	55,369,435.00	(20,836,635.00)	160.3
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хий	8,004,400.00	6,203,600.00	1,800,800.00	77.5
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,789,000.00	34,678,600.00	3,110,400.00	91.8
70	Бусад урсгал шилжүүлэг	37,789,000.00	34,678,600.00	3,110,400.00	91.8
74	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	37,789,000.00	34,678,600.00	3,110,400.00	91.8
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,037,928,065.42	972,907,948.00	65,020,117.42	93.7
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	903,452,200.00	838,538,600.00	64,913,600.00	92.8
99	Улсын төсвөөс санхүүжих	903,452,200.00	838,538,600.00	64,913,600.00	92.8
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	134,475,865.42	134,218,700.00	257,165.42	99.8
104	Орон нутгийн төсвөөс	134,475,865.42	134,218,700.00	257,165.42	99.8
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		150,648.00	(150,648.00)	
112	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		150,648.00	(150,648.00)	
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		70,042,757.21	(70,042,757.21)	
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		68,136,191.87	(68,136,191.87)	
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	38.00	38.00		100.0
134	Удирдах ажилтан	1.00	1.00		100.0
135	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00		100.0
136	Үйлчлэх ажилтан	14.00	14.00		100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүйн хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оныг "Залуучуудын хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 12 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 96,2 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус сургууль нь 38 орон тоо батлагдсанаас 34 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 он 11 сард Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдаж, 90,8 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,827.0 мянган төгрөгөөр буюу 3,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	70,042,7	68,136,1	1,906,6
Авлага			
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	53,281,4	52,381,5	(899,9)
Үндсэн хөрөнгө	742,711,0	781,344,4	38,633,4
Нийт хөрөнгө	866,035,1	901,862,1	35.827.0
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	866,035,1	901,862,1	35.827.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	866,035,1	901,862,1	35.827.0

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 68,136.1 мянган төгрөг болж өмнөх оноос 1,906.6 мянган төгрөгөөр буурсан нь мөнгөн зарлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл байхгүй.

Бараа материал дансны үлдэгдэл 52,381.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 899.9 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн бараа материал, бусад хангамжийн бараа материал данснаас нийт 5,824.3 мянган төгрөгийн материалыг акталж данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө данс 781,344.4 мянган төгрөг болж 38,633.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 23,699.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, хандиваар 52,724.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил орлогод авсан. Тайлант онд 184,191.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл байхгүй.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 883,948.1 мянган төгрөг, орон нутгийн санхүүжилтээс 134,475.8 мянган төгрөг, нийт 1,018,423.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 1,018,423.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 883,948.1 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 840,672.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 134,218.7 мянган төгрөг, нийт 974,891.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 974,891.4 төгрөг буюу 95,7 хувьтай байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 974,891.4 мянган төгрөг буюу 95,7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлын төсвийг 49,119.5 мянган төгрөгөөр, нормативт зардал 2,579.5 мянган төгрөгөөр, бүх төрлийн даатгалын зардлыг 7,045.0 төгрөгөөр тус тус төлөвлөгдсөнөөс дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	71801-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	2,135,5	2,135,5	-	100,0
2	80312 Сургалт семинар	1,067,3	1,067,3		100,0
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	2,134,5	2,134,5	-	100,0
4	81801 Үдийн цай хөтөлбөр	42,246,2	34,678,6	7,567,6	82,1
5	81806 Дотуур байрны үйлчилгээ	48,836,5	44,426,2	4,410,3	91,0
6	81816 Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх	31,297,0	31,297,0	-	100,0
7	81823 Мэргэжил дээшлүүлэх	4,802,6	4,802,6		100,0
8	81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	6,440,0	4,718,7	1,721,3	73,3
9	81834 Боловсролын стандарт сургалтын үйл ажиллагаа	584,587,9	545,383,5	39,204,4	93,3
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	140,001,6	124,778,5	15,223,1	89,1
11	81844 Төрөлжсөн сургалт	5,164,3	5,164,3	-	100,0
12	81848 түрээсийг сурах бичиг	1,710,0	1,710,0		100,0
13	80111 төрийн өмчийн барилгын тогтмол зардал	134,218.7	133,961.5	257.2	99%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801-80226	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Байр ашиглалтын үйлчилгээ 100%	2,135,5	2,135,5
2	71801-80312	2023-12-31	Сургалтын чанар сайжруулах	Сургалт семинар 100,%	1,067,3	1,067,3
3	71801-81605	2023-12-31	Урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийг дэмжих 100%	1,784.8	1,784.8
4	71801-81801	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Үдийн цай хөтөлбөр 89.9%	42,246,2	34,678,6
5	71801-81806	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Дотуур байрны үйлчилгээ 91.0%	48.836.5	44.426.2
6	71801-81816	2023-12-31	Хүүхэд бүрийг компьютертой болгох	Хүүхдэд ээлтэй орчин 100%	31,297,0	31,297,0
7	71801-81823	2023-12-31	Мэргэшүүлэх	Мэргэжил дээшлүүлэх 97.3%	4,802,6	4,802,6
8	71801-81827	2023-12-31	Иргэн бүрийг бичиг үсэгтэй болгох	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр 67.8%	6,440.0	4,718,7
9	71801-81834	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Стандарт сургалтын үйл ажиллагаа 94.05%	584,587,9	545,383,5
10	71801-81835	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах 73.8%	140,001,6	124,778,5
11	71801-81844	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Төрөлжсөн сургалт 0%	5,164,3	5,164,3
12	71801-81848	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Түрээсийн сурах бичиг 77.8%	1,710,0	1,710,0

Үдийн цай хөтөлбөр, дотуур байрны үйлчилгээ арга хэмжээнүүд нь дутуу хэрэгжсэн нь орон тоо хэмнэсэн, хүүхдийн ирцтэй холбоотойгоор хэмнэгдсэн. Бичиг үсгийн боловсрол арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь хамрагдах хүүхдийн тоо муу ирц хангалтгүйгээс дутуу хэрэгжсэн байна.

Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь томуу, томуу төст өвчин ихэссэн, ЕБС цахимд шилжсэнтэй холбоотойгоор хүүхдийн ирц буурч хэмнэгдсэн.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд цахим дэлгүүрээс 17,580.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Үдийн цай хөтөлбөрт

Би Өү М Би ХХК-аас хүнсний материал авахаар худалдан авах ажиллагаа хийгдсэн. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 89 хувьтай байна. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлуулж зохих хууль, журмын дагуу гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах анхан шатны бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь, Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 02 дүгээр сарын 14-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,000,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 20,000.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16,000.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 3 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласны үр дүнд ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Сүмбэр сумын сургууль нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх 12 төрлийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 30,500.4 мянган төгрөгөөр

- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 14,881.6 мянган төгрөгөөр
- Бүх төрлийн даатгалын зардлыг 7,045.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус Ерөнхий боловсролын сургууль нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 153 мэдээллийг байршуулж 6 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3 “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулж, зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүнба өмнөх аудитаар өгсөн алдаа зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 3 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад хэрэгжээгүй тул аудитын тайланд зөрчлөөр тусгав.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	8,319,7	2	8,319,7	100,0
Албан шаардлага	4	38,533,2	4	38,533,2	100%
Зөвлөмж					
Нийт дүн	6	46,852,9	6	46,852,9	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал ажиглагдсангүй

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 37,470.3 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 36,341.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 501.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.2 Албан шаардлага

Бусад хангамжийн бараа материал дансанд 2023 оны жилийн эцсээр 36,341.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “Нөөцлөх шаардлагатай бараа материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал бэлтгэх, нөөцлөхгүй”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төсөвлөж зарцуулах” санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан” Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн цаашид их хэмжээний бараа материал нөөцлөхгүй байх албан шаардлага өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бензин зарцуулалтын тайлан гаргаагүй гарын үсэг зуруулаагүй 501.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх , санхүүгийн тайланд тусгахыг хориглогно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийн дагуу тоцоо бодох анхан шатны баримтын бүрдэлд хяналт тавих зөвлөмж өгсөн.

Дээрх албан шаардлага болон зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахууны тайлан гаргаагүй	1	501.1					1	501.1				
Бусад хангамжийн бараа материал их хэмжээгээр нөөцөлсөн	1	36,341.0			1	36,341.0						
Дүн	2	36,842.1	1		1	36,341.0	1	501.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 6 мэдээ хугацаа хоцроон мэдээллсэн	1							
Дүн	1							
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn